



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/SGO

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цээл сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2022/09 дугаар гэрээт шинэ суурьшлын бүсэд 10/0.4 кВ-ын 250 кВА хүчин чадалтай КТПН, 0.4 кВ-ын ЦДАШ, дэд станц суурилуулсан ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- | | | |
|-----------------|---------------|--|
| Комиссын дарга: | Б.Бямбадорж | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор) |
| Гишүүдэд: | М.Мандаххүү | (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга) |
| | З.Жаргалтуяа | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн) |
| | Б.Буянхишиг | (Цээл сумын Засаг дарга) (тохиролцсноор) |
| | Б.Лхагва-Очир | (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн) |
| | Ц.Амарсанаа | (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч) |
| | Д.Отгонжаргал | (Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч) |


2.

| | |
|----------------------------------|---|
| Б.Батбилэг | (Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч) |
| Б.Балдорж | (Орон нутгийн өмчийн газрын хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн) |
| Б.Бээжин | (“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер) |
| Б.Анхбаяр | (“Орон зай консалтинг” ХХК-ийн цахилгааны инженер) (зохиогч) |
| С.Мөнхбаатар | (“УБ-Электро монтаж” ХХК-ийн ерөнхий инженер) (гүйцэтгэгч) |
| Нарийн бичгийн дарга:Б.Насанбуян | (Цээл сумын засаг даргын Тамгын газрын дарга) (захиалагч) |

2.Барилга байгууламж, шугам сүлжээний угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа техникийн комиссын дүгнэлт, гэрээнд тусгагдсан зураг төсөлтэй нийцүүлэн холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б:Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), инженерийн байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Цээл сумын Засаг дарга (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ